

**НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-20

<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/</i>	3-5
<i>2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	5-20

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Нийгмийн бодлогын байнгын хорооны
03 дугаар сарын 15-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 9 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 08 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнх-Оргил.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Анужин тогтоолын төслийн талаар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл үг хэлэв.

П.Анужин: “Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 3
Бүгд: 9
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын референт Г.Нямсүрэн, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Байнгын хорооны дарга П.Анужин тогтоолын төслийн талаар танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Ц.Идэрбат, М.Оюунчимэг, С.Одонтуяа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга П.Анужин, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нар хариулж, тайлбар хийв.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Байнгын хорооны дарга П.Анужин, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, С.Чинзориг нар үг хэлэв.

П.Анужин: “Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Нийгмийн бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 06 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 58 минут үргэлжилж, 16 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 93.7 хувийн ирцтэйгээр 16 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
НИЙГМИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

П.АНУЖИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 03 дугаар сарын 15-ны өдөр,
Лхагва гараг

Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 15 цаг 08 минут.

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

П.Анужин: Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэндээ хаврын чуулганы мэнд хүргэе.

Байнгын хорооны гишүүдийн олон хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 56.2 хувьтай бүрдсэн тул Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хуралдаанд хүрэлцэн ирсэн болон ирээгүй гишүүдийг та бүхэндээ танилцуулъя.

Баярсайхан гишүүн ирсэн байна. Батлут гишүүн ирсэн. Жаргалмаа гишүүн ирсэн. Сандаг-Очир гишүүн ирсэн. Сарангэрэл гишүүн ирсэн байна. Саранчимэг гишүүн ирсэн. Чинбүрэн гишүүн ирсэн байна. Чинзориг нарын гишүүд хуралдаа ирсэн байна.

Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэндээ танилцуулъя.

1.Байнгын хорооны тогтоол батлах тухай /Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

2.Байнгын хорооны тогтоол батлах тухай /03 дугаар сарын Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хэлэлцэх асуудлын талаар саналтай гишүүд байна уу?

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай/

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэгт Үндэсний зөвлөлийн гишүүнийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж, 5 жилийн хугацаатайгаар томилно гэж заасан байдаг.

Энэ хүрээнд 2017 онд Улсын Их Хурлаас томилсон Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагч ажил олгогчийг төлөөлсөн зарим гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссан, чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн байгааг та бүхэн мэдэж байгаа.

Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд заасны дагуу даатгуулагч ажил олгогчдыг төлөөлөх байгууллага болох Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас холбогдох хүмүүсийн нэрийг дэвшүүлж, Байнгын хороонд ирүүлээд байна.

Нэр дэвшигчдийн мэдээлэл хуулийн лавлагааг та бүхэнд тараасан байгаа. Та бүхэн авсан байгаа. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31.2-т заасны дагуу нэр дэвшигчдийн материал чуулганы завсарлагааны хугацаанд ирсэн тул ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын 5 өдөр дотор сонсголын товыг тогтоож, нийтэд мэдээлэх хуулийн заалтын дагуу өнөөдөр бид сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Та бүхэнд тогтоолын төслийг танилцуулсан байгаа.

Хяналт шалгалтын тухай хуулийн 31.5 дахь хэсгийн дагуу бид дор хаяж 14-өөс доошгүй өдрийн дотор сонсголд оролцогчдыг бүртгэх, нэр дэвшигчээс асуулт асуух, саналыг бичгээр урьдчилан авах ажиллагааг явуулах учраас энэ өдрөөс хойш 14 хоногийн хугацааг тоолбол хамгийн боломжит хугацаа нь 2023 оны 4 сарын 10-ны өдөр байна. Нэг дэх өдөр таарч байгаа. Мөн сонсголыг даргалах саналтай гишүүн байвал саналаа хэлж бас та бүхэн болно.

Ингээд Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх гишүүд байвал нэрсээ өгнө үү. ЭМДҮЗ-ийн гишүүд. Сайд нь сууж байна. Эзэнтэй болох даруй шаардлагатай байгаа гэдгийг бас салбарын сайд сая та бүхэнд хэлж байна. Тэгэхээр бид нар энэ хугацаа нь дууссан гишүүдийг яаралтай чөлөөлж, дараагийн нэр дэвшигчдийг ажилд нь сонгон шалгаруулалтаа нээлттэй хийж дараагийн гишүүдийг томилох яаралтай бас шаардлага байгаа гэдгийг, цаг үеийн шаардлага байгаа гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Өнөөдөр бид нар зөвхөн тов тогтох юм. Тэгээд дараа нь бид нар яг нөгөө асуултаа асууж, сая дэгийг танилцууллаа. 14 хоногийн хугацаанд яаж бид нар асуултаа асууж, энэ сонсголыг явуулах талаар.

Одоо Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонсголын. Уучлаарай асуулт асуух гишүүн Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллах шаардлагатай юм байгаа юм. Тэгээд төлөөллийн хувьд Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөлгүйгээр нэлээн удаан хугацаанд

үйл ажиллагаа явуулж байгаа. Өнгөрсөн удаа бид нар энэ үйл ажиллагааг бас зохион байгуулсан л даа. Харамсалтай нь 1 хүн нь олонхын дэмжлэг авч чадаагүй учраас одоо хүртэл энэ үйлдвэрчний эвлэлийн байгууллагын төлөөлөл үүнд байхгүй болчихоод байгаа юм.

Өнгөрсөн энэ гишүүнийг сонгох сонсгол явуулсан мэдээлэл, шинжээч томилох энэ асуудлыг би хариуцаж байсан. Тэгээд энэ удаа би маш тодорхой хүн санал болгоё гэж бодож байгаа. Идэрбат гишүүн энэ чиглэл дээр ажиллавал нэлээн бас хариуцлагатай ажиллачих болов уу гэсэн ийм саналтай байна.

Тэгээд энэ дээр чинь анх удаа нөгөө уг нь бол Байнгын хороогоор ороод л Улсын Их Хуралд оруулаад болчихдог байсан бол одоо шинжээч томилдог, сонсгол хийдэг ийм шинэ практик руу орсон. Бас нэлээн ажиллагаа, нэлээн тийм бодит хандлага шаардлагатай болдог юм. Тэгээд энийг яаралтай хийх нь зүйтэй. Тэгээд ажлын хэсгийг нь ахлаад, ахлах хүнээ томилоод ажлын хэсгийн гишүүдээ томилчих юм бол энэ ажил хурдан явах бололцоотой гэсэн саналаа хэлэх гэсэн юм.

П.Анужин: Сарангэрэл сайдад баярлалаа. Гишүүд холбогдох асуудалтай холбоотойгоор асуулт асууж дууслаа. Та бүхэнд нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, сонсгол даргалагчийг томилох тухай тогтоолын төслийг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт нийтийн сонсголын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118., 119 дүгээр зүйлийн 119.1 дэх хэсгийг үндэслэн Нийгмийн бодлогын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн даатгуулагчийг болон ажил

олгогчийг төлөөлсөн гишүүнд Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхимаас нэр дэвшүүлсэнтэй холбогдуулан нэр дэвшигчийн сонголыг 2023 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулахаар товлоусугай.

Нэр дэвшигчийн сонгогч даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Идэрбатыг томилсугай.

3.Нэр дэвшигчийн сонголын талаар нийтэд мэдээлж бэлтгэх ажлыг хангаж, холбогдох хуульд заасны дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо, мэргэжил, арга зүй, техник зохион байгуулалтын туслацаа үзүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт тус тус даалгасугай гэсэн ийм тогтоолын төслийг та бүхэндээ танилцуулж байна.

Сая Сарангэрэл гишүүн тодорхой нэр дэвшүүлсэн сонгогч даргалагчаар Идэрбат гишүүнийг нэр дэвшүүлж байна.Идэрбат гишүүнийг сонгогч даргалагчаар томилох тухай би сая тогтоолын төсөлд тусгаад уншлаа. Өөр саналтай гишүүд бас байвал саналаа илэрхийлж болно.

Түрүүн асуулт тасалчихсан дуусчихсан тийм ээ. Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонголын товыг тогтоох, сонгогч даргалагчийг томилох тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэдэг томъёоллоор санал хураалт явуулья.

Тогтоолын төслийг 66.7 хувиар баталлаа.

15.16 цаг

Хэлэлцэх асуудлынхаа хоёрдугаарт оръё.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 3 дугаар сард хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хорооны тогтоолоор батална.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.5 Улсын Их Хурлын дарга сар бүр хэлэлцэх асуудлын цаглавар батлах бөгөөд энэхүү дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж, дагаж мөрдүүлэхээр заасан байгаа.

Та бүхэнд Байнгын хорооны тогтоолын төсөл, хэлэлцэх асуудлын цаглавартай хамт тараасан байгаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд саналаа өгнө үү.

Цаглавартай холбоотой. Тийм 2 зүйл байгаа өнөөдөр. Үг, санал хамт явж байгаа. Үг хэлж, санал асуух гишүүдийг. Оюунчимэг гишүүн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнээр тасалж байна.

Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Жаргалмаа: Сайн байцаана уу? Та бүхэндээ бас хаврын чуулганы эхний өдрийн мэндийг хүргэе. Үнэхээр Нийгмийн бодлогын байнгын хорооны нэн тэргүүний хэлэлцэх асуудал ялт ч үгүй нийгмийн даатгалын багц хууль байгаа. Сая тойргоор явж сонгогчтой уулзаж байхад яг нийгмийн даатгалын багц хуулиа энэ хаврын чуулганаараа баталж амжих уу, үгүй юү гэдэг ийм асуулгыг маш ихээр тавьж байна.

Нөгөөтээгүүр яг Их Хурлын даргын бас Март-8-наар эмэгтэй гишүүдийг хүлээж авч уулзахдаа аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг дахь оролцоог нэмэгдүүлэх тухай хуулийг бас энэ хаврын чуулганаар хэлэлцэх жагсаалтад оруулья гэдэг нэн таатай

мэдээлэл байсан. Энэ бас хэлэлцэх гэж байгаад бас баяртай байна.

Энэ дээр зүгээр юу хамгийн гол анхаарал байсан бэ гэвэл сонгогчдынхоо бас асууж байсан асуултыг би бас тавимаар байна. Өөрөөр хэлэх юм бол аж ахуй эрхэлж байгаа эмэгтэйчүүд бид нарт юу хэрэгтэй байна вэ гэвэл зээл маш их хэрэгтэй байна гэдэг зүйлийг уншихаар ярьж байсан. Тэгэхлээр зээлийн асуудлыг бид нар бол яг хуульдаа бас нарийн, сайн тусгаж өгөх шаардлагатай байх гэж бас энэ саналаа бас та бүхэндээ хэлье гэж бодож байна.

Нөгөө талаар түрүүний бас асуулт асуулгүй өнгөрөөчихлөө. Нийтдээ сонсгол гэдэг бол олон хүн нэр дэвшээд, тэр дундаасаа бид нар шаардлага хангасан 1-нийг сонгох энэ сонголт гэж би ойлгож байгаа. ЭМДҮЗ яг өнөөдрийн байдлаар хэчнээн гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байгаа билээ? Яг тулсан гишүүд ороод ирвэл бид нар хэн нэгнийг хасах эрхгүйгээр шууд сонгоод л явчихдаг шүү дээ лээ. Яг энэ нэр дэвшигчдийнхээ нэрсийг нэмэх шаардлагатай юм болов уу гэсэн бодол байна.

Өөрөөр хэлэх юм бол үнэхээр Үйлдвэрчний эвлэл болон ажил олгогч эзэд мөн Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхимаас ингээд нэр дэвшүүлж байгаа орж ирж байгаа хүмүүс маань шаардлага хангахгүй бол бид хэнийг нэр дэвшүүлэх вэ? Өөрөөр хэлэх юм бол нэг ажлыг нэгмөсөн хийхийн тулд дараа дахиж нэр дэвшигчийг оруулж ирэхгүйн тулд нэгмөсөн нөгөө нөөц нэр дэвшигчтэйгээр бас оруулж ирэх ёстой байх гэж бодож байна. Энэ дээр тайлбар авъя. Баярлалаа.

П.Анужин: Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурал бас хаврын чуулганаар хэлэлцэх асуудлынхаа дараалалд сая таны дурдсан Даваажсанцангийн Сарангэрэл гишүүн нарын өргөн барьсан эмэгтэйчүүдийг энэ бизнес эрхлэх эрхлэлтийг дэмжих тухай хууль бол энэ хэлэлцэх асуудлын дараалалд

бол орсон байгаа. Албан ёсоор орсон тийм ээ, та энийг түрүүн бас хэллээ.

Дараагийнх нь бол бид нар 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа цаашидаа энэ 9 хүний бүрэлдэхүүнтэй 3 газраас 3, 3-н хүнийг санал болгодогийг та мэдэж байгаа.

Хэрвээ энэ хүмүүс шаардлага хангахгүй бол ахин нэр дэвшиж, ингэж ахин сонсгол явуулах ийм л горимтой. Энэ ч талаасаа бас босго өндөр болчихсон. Өмнө нь бас энэ ЭМДҮЗ ингээд байгуулагдахгүй нэг гол шалтгаан бол энэ байгаад байгаа гэдгийг бас та мэдэж байгаа.

Идэрбат гишүүн асуулт асууя.

Ц.Идэрбат: Ер нь энэ сая чуулганы завсарлагаар тойргоороо ажиллаж байхад энэ нийгмийн даатгалын багц хууль дээр маш олон асуудлууд яригдаж байна. Энэ эхний хэлэлцүүлгүүд хэлэлцэх эсэх нь ингээд явчихсан. Одоо ингээд ажлын хэсэг байгуулагдаад энэ удаа дараагийн яг энэ хууль дээр заагдсан зүйл, заалтуудаар иргэдээс санал хүсэлт сонсож байгаа гэж ингэж би ойлгож байгаа, ойлгосон. Эндээс бас тодорхой саналууд байгаа юм. Энэ хууль бол юу гэдэг юм тэтгэвэрт гарчихсан байгаа хүмүүсийн хууль, магадгүй 2 жилийн дараа гарах гэж байгаа ч хүний хууль байх. Магадгүй энэ өнгөрсөн одоо энэ мөрдөгдөж байгаа хуулийг харахад энэ 20-иод жилийн өмнө, 30-аад жилийн өмнө батлагдсан хууль байлаа шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр 30-н хэдтэй, 30-тай, 20-н хэдтэй залуучууд магадгүй энэ хуулиар тэтгэвэрт гарах байхгүй юу. Тэгэхээр би хэлэлцүүлэг дээр зөвхөн ахмадууд биш энэ залуучуудыг, дээрээс нь Монгол Улсад бизнес эрхэлж байгаа бизнесменүүдийн, бизнес эрхлэгчдийн гол ярьдаг хэлдэг зовлон бол цалингаа нэммээр байхад нийгмийн даатгалын энэ шимтгэл хураамжууд маш их дарамт учруулдаг. Цалингаа нэмэх нь битгий хэл

энэ бизнес цаашаа тогтох үгүйг бараг энэ нь шийдчих гээд байдаг гэсэн ийм зүйлийг ярьж байгаа юм.

Тэгэхээр би бол энэ нийгмийн даатгалын энэ багц хуулийн хэлэлцүүлэг дээр өндөр настнууд ч ороод, залуучууд ч ороод бизнес эрхлэгчидтэй ийм уулзалтуудыг бас сегментчилж хийгээд, дээрээс нь энэ чинь орон нутгийнх магадгүй Улаанбаатар алслагдсан дүүрэг гээд бас өөр өөр өнцгүүд эндээс гарч ирнэ.

Тэгэхээр ганцхан Төрийн ордонд хийгээд байх биш энэ аймаг, орон нутгаар явж энэ саяын хэлдэг залуучууд, ахмадууд, бизнес эрхлэгчдийг хамруулсан хэлэлцүүлгүүдийг бас хийвэл энэ хууль магадгүй 30 жил хэрэгжих энэ хууль энэ суурь хуулийг бид нар маш нухацтай авч хэлэлцэх ёстой юм гэж ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр Төрийн ордонд биш Төрийн ордноос гараад сум, орон нутаг, бизнесмен энэ хүмүүс дээр очиж уулзаж нийгмийн даатгалынхаа энэ хуулийн хэлэлцүүлэг юмнуудыг хийж, санаа оноог нь тусгах энэ ажлыг энэ ажлын хэсгийн хуралдаан энэ 3 сарын 27-нд болох юм байна. Дэд хэсгийн хуралдаан нь 21-нд болох юм байна. Энэ тал дээр бас би анхаараач энэ дээр яг ямар ямар газар, хэзээ, хаана, ямар хурал хийх гэж байгаа юм? Тийм төлөвлөгөө байгаа бол энэ Байнгын хорооны гишүүдэд бас танилцуулаач, энэ хүмүүсээс саналыг нь бас аваач гэсэн ийм нэгдүгээрт санал байна гэдгийг хэлье.

П.Анужин: Идэрбат гишүүнд баярлалаа. Идэрбат гишүүний бас асуулт, саналд хариулт өгье.

Бид нар сая чуулган завсарлах хугацаанд нийгмийн энэ даатгалын багц хуулиа танилцуулах, хэлэлцүүлэг, санал авах уулзалтуудыг бид нар ахмадын төлөөлөл Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, залуучууд, сайн дурын нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид, ажил

олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн төлөөлөлтэй уулзалт хийж, саналыг нь бид нар авсан байгаа.

Хөдөө орон нутагт яг таны хэлсэнчлэн хөдөө орон нутагт бид нар бас уулзалтуудыг хийж эхэлсэн. Булган, Орхон, Дархан аймгуудад бид нар ажилласан байгаа.

Цаашидаа ажлын хэсгүүд яг одоо таны хэлж байгаагаар эх орныхоо 4 зүг 8 зовхис хөдөө орон нутагт бол ингэж яг саяын хэлсэн нийгмийн бүхий л давхаргуудыг хамарч хуулиа танилцуулах, хуулийнхаа төслийг танилцуулж, санал авах ийм уулзалт, хэлэлцүүлгүүдийг хийгээд явна. Энэ цаглавар мөн Байнгын хороон дээр гарсан байгаа гэдгийг танд хэлье. Маш үнэ, цэнтэй чухал санал. Яг таны энэ саналыг сая Байнгын хороо завсарлах явцдаа боловсруулчихсан байгаа гэдгийг танд бас дуулгая. Одоогийн байдлаар Булган, Орхон, Дархан аймгуудад ажилласан байгаа. Цаашидаа 21 аймагтаа ингэж ажиллаж, ажлын хэсгүүд явж ажиллана гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Сая Идэрбат гишүүн чухал асуудал хөндлөө. Сая чуулганы завсарлагаагаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас л ерөнхийдөө зохион байгуулалттай манай Нийгмийн бодлогын байнгын хороо хамтарч оролцоод хэд хэдэн хэлэлцүүлэг хийлээ. Манай ажлын хэсгийнхэн бол яах хэрэгтэй санагдлаа надаа. Энэ нийгмийн даатгалын багц хууль чинь өөрөө их улс төрийн оролцоогүйгээр шийдэх ёстой их чухал хууль. Тэгэхээр сая Орхон болон тэр нэг, хоёр аймагт болсон хэлэлцүүлгийг харахад энд ажлын хэсгийн ахлагч өөрөө манлайлаад цуг ингээд яваад тэгээд хэсэг яг гишүүдээсээ яг тэр хүрээнд мэдээлэл авахын тулд нэлээд олон зохион байгуулалттайгаар энд дарга өөрөө

санаачилгаа гартаа аваад хийх хэрэгтэй байна.

Тэгэхгүйгээр энэ Нийгмийн даатгалын багц хууль нийгмийн зөв ойлголцол төрүүлж чадахгүйгээр явбал хаврын чуулганы хэлэлцэх асуудал дээр энэ маань бас яах вэ гэдэг асуудал байгааг өөрөө мэдэж байгаа байх. Тэгэхээр бид нар үүн дээрээ үнэхээр анхаарах хэрэгтэй байна.

Дээрээс нь тэр Чинзориг сайд эртээд бас их зөв яриад байна лээ. Тэр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл тэгээд яг энэ Сангийн яамтайгаа энэ хуулийн заалтууд дээр маш сайн хэлэлцүүлгийн явцад ажиллах шаардлага байна шүү дээ.

Тэгэхээр бид нар энэ ажлын хэсгийг нэг цуглуулж байгаад өргөн бүрэлдэхүүнтэй оруулаад, энэ хууль дээрээ нэлээд анхаарч нухаж суух хэрэгтэй байна. Ялангуяа тэр саяын энэ өнөөдөр бид нар яриад л байна энэ Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн зохион байгуулалт, бүтэц, санхүүжилт, хүний нөөц энэ тэрийг сайжруулахгүйгээр энэ өөрөө явахад хэцүү юм байна гэдгийг бид нар бас харж байгаа.

Харин өмнөх чуулганы, намрын чуулганы хугацаанд бид энэ Нийгмийн даатгал, Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийг анх удаагаа нээлттэй сонсголоор явуулдаг болсны үр дүн бас гарсан.

Яагаад гэвэл ингээд л нэг хүн орж ирээд л механикаар, автоматаар ингээд л сонгоод явдаг бол хэн нь хэн байна? Яг энэ хүн мэргэжлийн түвшинд энэ хүн зөв үү, буруу байна уу, тоо боддог хүн байна уу, боддоггүй юм байна уу? Одоо тулгараад байгаа асуудлыг шийдэж чадах хүн орж ирж байна уу, үгүй юу гэдгийг бид нар асуултаар нь, хариултаар нь, эрдэмтдийн, судлаачдын, шинжээчдийн

дүгнэлтээр хүртэл гараад заримыг нь буцааж байсан. Өнөөдөр орж ирж байгаа хүмүүсийн нэрсийг бас харж байна.

Тэгэхээр энэ дээрээ бид заавал нөгөө горим өөрчлөх боломжгүй гэж бас өөрчлөх бололцоо байж магадгүй тээ. Энэ дээр манай ахлах зөвлөх, зөвлөхүүд бас ажиллаад сая Жаргалмаа гишүүний хэлж байгаагаар яг нөгөө тулчихсан яг тэгдэг юм. Тийм, өмнө нь ч байж байхад 3 хүн гээд л 3 хүн оруулж ирээд л, 2 хүн гээд л 2 хүн орж ирээд л, тэгээд нөгөө шаардлага хангахгүй гээд дүгнэлт гарангуут улс төржсөн юм шиг бөөн хэрүүл уруул гараад л асуудал үүсэж байсан.

Тэгэхээр бид нар одоогийн нээлттэй сонсголыг бас энэ өмнө нь гарч байгаа зарим алдааг давтахгүйн тулд орж ирж байгаа хүмүүсийг магадгүй та энэ дээр өшөө санал хүмүүс нь байна уу гээд оруулж ирээд нээлттэй сонсголыг явуулчихвал бас их давуу талтай юм байна гэж би өмнөх сонсголоос харсан.

Тийм учраас бид нар энэ дээр санаачилгатай ажиллах хэрэгтэй байна гэдгийг бас би хэлье гэж бодож байна.

Хоёрт нь энэ цаглаврыг би харж байна. Мэдээж яг жагсаалтад орчихсон асуудлууд байна. Нийгмийн даатгалын багц хууль, Аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн гээд энэ маш чухал хууль. Хүмүүс харж, хүлээж байна.

Нөгөө нэг асуудал нь би бас өмнө нь Байнгын хороон дарга байхдаа зөвхөн цаглаварт болж өгвөл аль болох бүгдийг нь, гол юмнуудаа оруулах, дээрээс нь нийгмийн тухайн цаг үеийн тулгамдсан асуудлуудаар яг ингээд асуудлуудыг бид нар урьдчилж хараад, урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваад бас ингээд ажилладаг. Манай Байнгын хорооныхон энэ дээр бүгд их гоё гоё санаанууд гаргадаг.

Одоо хүүхэд хамгааллын асуудал нээрээ хүнд байдалд байна. Ялангуяа ахуйн хүрээнд хүүхдийн хүчирхийлэл хаалттай хаалганы цаана арай дэндүү түвшинд хүрч байна шүү дээ. Одоо энэ 3 настай хүүхэд өнөөдөр хүртэл ухаан ороогүй ингээд 8, 9 хонож байна. Тэгээд энэ нь юу болж байна гэхлээр уг нь бид нар өмнөх 4 жилд хүүхэд хамгааллын мөнгө 11 тэрбум төгрөг шаардлагатай байна гэхэд 1 тэрбум хүрэхгүй байгаа санхүүжилтийг нь бид 6 тэрбум, 8 тэрбум гээд нэмж өгсөн. Одоо Сарангэрэл дарга мэдэж байгаа тэр хүүхдийн байцаагчийн орон тоог нэмэхгүй бол болохгүй нь гээд. Одоо яг эмэгтэйчүүд манлайлаад бүр Нямдорж сайд дээр орж уулзаж байгаад бид 130 хүүхдийн байцаагчийн .../минут дуусав./

П.Анужсин: Оюунчимэг гишүүнд 1 минут өгье.

М.Оюунчимэг: Бид бүр эмэгтэй гишүүд Хууль зүй, дотоод хэргийн тухайн үеийн сайдтай ярьж байгаа төсөвт нь хүртэл 130 орон тоо, санхүүжилтийг нь суулгаад өнөөдөр бас энэ үр дүнгээ өгч байгаа. Гэтэл хаалганы цаана энэ амьд аймшигт хүчирхийлэл яваад байна.

Тэгэхээр Гэр бүлийн тухай хуулийг одоо тэр санаачилсан гишүүд, дээрээс нь Хууль зүй, дотоод хэргийн сайдтайгаа ярьж байгаад энэ хуулийг оруулж ирэх дээр бас Нийгмийн бодлогын байнгын хороо шахаж идэвхтэй ажиллах шаардлага энэ байна гэдгийг би бас хэлэхийг хүсэж байна.

Тэрнээс биш бид хүүхэд хамгааллын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, санхүүжилт тусгасан, хүний нөөц шийдсэн. Гэтэл эрүүгийн энэ ноцтой хэргүүд байгаад байгаа учраас эцэг эхийг хариуцлагажуулах энэ хуулийг тэр эрүүгийн санцгийг нь хатуу болгох, хариуцлагыг нь тооцдог байх. Энэ хуулийг хаврын чуулганд ороход Нийгмийн бодлогын байнгын хороо бас манлайлж

оролцох ийм шаардлага байгаа гэдгийг хэлье.

Тийм учраас энэ хэлэлцэх асуудал дээр бид бас цаг үеийн асуудлуудыг оруулах бололцоо хэр байна вэ гэдэг дээр бид нар анхаарвал зөв болов уу гэсэн байр сууриа илэрхийлье гэж бодож байна.Баярлалаа.

П.Анужсин: Оюунчимэг гишүүнд баярлалаа.

Намрын чуулганы завсарлагааны үеэр бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам зохион байгуулж хэлэлцүүлэг хийгээгүй. Бүгд бол Их Хурлын дэргэдэх Нийгмийн бодлогын байнгын хороо бие дааж зохион байгуулсан ийм хэлэлцүүлгүүдийг бол маш амжилттай явуулж, бид нар бол ер нь маш их энэ нийгмийн даатгалын багц хуульд шүүмжлэлтэй хандаж байгаа энэ бүхий л газруудын саналыг харьцангуй богино хугацаанд бид нар авч, шахаж, хуулийнхаа төсөл дээр нэмж энэ ажиллах үйл явц аль хэдийн эхэлсэн байгаа гэдгийг бас танд дуулгая. Энийг танд хэлье.

Дараагийн зүйл нь ажиллаж байгаа гэдгийг, саналуудаа бид нар багцлаад авчихсан. Бид нар энэ хуульд тусгуулах энэ саналуудаа нэгтгээд ажиллаж байгаа гэдгийг танд хэлье.

Хоёрдугаарт энэ Хүүхэд хамгааллын тухай хууль гэж байна. Баярсайхан гишүүн Хүүхэд хамгааллын тухай энэ хуулийн хэрэгжилтийг хянах энэ ажлын хэсгийг ахалсан. Тайлангаа хоёр 7 хоногийн дараа Нийгмийн бодлогын байнгын хороогоор хэлэлцүүлэх ийм хуваарьтай байгаа.

Тэгэхээр бид нар хоёр 7 хоногийн дараа энэ хүүхэд хамгааллын хууль хэрхэн хэрэгжиж байгаа юм бэ, алдаа нь хаанаа байгаа юм бэ, оноо нь хаанаа байгаа юм бэ гэдэг бүх асуудлуудыг дэлгэрэнгүйгээр хоёр 7 хоногийн дараа бас сонсохоор байгаа гэдгээ хэлье.

Цаглаврын хувьд та өмнө нь Байнгын хорооны дарга хийж байсан хүн мэдэж байгаа. Бид нар энэ цаглавар дээр ерөнхий хуулиуд тусгагддаг. Таны саяын хэлсэнчлэн цаг үеийн асуудлуудыг бид нар өөрсдөө энэ Байнгын хороогоороо тухайн энэ хөтөлбөрүүд, энэ графиктаа тусгаад явах ийм бүрэн боломжтой байдаг гэдгийг бас танд хариулъя.

Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Тэгвэл нийгмийн даатгалын нөгөө ажлын хэсэг маань хуралдаад асуудлаа бүгдээрээ хэлэлцэх нь гээд би ойлголоо тийм ээ? Нөгөө Эмийн түр хороо маань Нийгмийн бодлогын байнгын хорооноос бид томилсон энэ Хөгжлийн банкны түр хороо шиг бас эмийн асуудал. Сая би сонгогчидтойгоо их уулзлаа, бас иргэдийн хүсэлтээр уулзалтууд хийлээ. Эмийн чанар, эмийн үнэ, нөгөө эмийн асуудлыг маш их ярьж байна.

Тэгэхээр бид нар эмийн хянан шалгах түр хорооныхоо дүгнэлт, бид нар хуралдаач үгүй байгаа шүү дээ. Цахимаар 2, 3 хуралдах гэж байгаад бас болоогүй. Чинбүрэн гишүүн маань мэдэж байгаа байх. Эмийн түр хорооныхоо асуудал дээр Байнгын хороо яаж хандах вэ? Энэ эсвэл шууд чуулганаар ороод дүгнэлтээ хийгээд явчхаж болох юм уу? Тэгээд ажлын хэсэг маань бас хуралдаагүй байгаа шүү дээ. Тэгэхээр энэ дээр ямар байр суурьтай байна?

П.Анужин: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Энэ эмийн ер нь энийг бол бид нар тайлангаа шууд Улсын Их Хурал дээр сонсож тайлагнах ёстой. Тайлан сонссоноор хугацаа нь дуусчихсан байхгүй юу. Тэгэхээр бид нар сонссоноор Түр хорооны ажиллах хугацаа бол дуусаж байгаа.

Ер нь бид нар ямар чиглэлтэй цаашдаа ажиллах вэ гэхээр өмнө нь бид нар Байнгын хороон дээр ч гэсэн ярилцаж

байсан. Энэ эмийн асуудлаа нэгэнт Улсын Их Хурлын дэргэд мэргэжлийн Байнгын хороо нь байхад Байнгын хороо нь өөр дээрээ энэ асуудлаа татаж аваад, ажлын хэсэг байгуулаад ингээд цаашаа ажиллах нь ажил үүргийн уялдааны хувьд зөв юм гэсэн ийм бодлого, чиглэл яригдсаныг бас та бүхэн мэдэж байгаа гэдгийг та бүхэнд хэлье.

Ер нь бас энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудлын дараалалд энэ Эм эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Донорын тухай хууль, тэгээд Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль гээд олон чухал хуулиуд бас хэлэлцэгдэхээр ингэж яригдаж байгаа. Тэгэхээр энэ хуулиудыг бас яаралтай Засгийн газраас өргөн барих ажлыг бас энэ салбарын яам Эрүүл мэндийн сайд бас яаравчилж хичээнгүйлэн ажиллах шаардлагатай. Өнөөдөр өглөө ч гэсэн Улсын Их Хурлын нээлтийн чуулган дээр яригдсан асуудлуудаас бас харахад энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль бол энэ эрүүл мэндийн ерөөсөө суурь асуудал болчхоод байгаа.

Үүнийг бид нар хууль, эрх зүйн хүрээнд шийдэхгүйгээр эрүүл мэндийн ямар ч асуудлууд явахгүй байгаа гэдгийг энэ мэргэжлийн Байнгын хорооны гишүүд та бүхэн бүгд мэдэж байгаа учраас Байнгын хорооны зүгээс Эрүүл мэндийн яамыг энэ хуулиа яаралтай яаралтай гээд нөгөө бушуу туулай борвиндоо баастай гэж тийм ээ, ийм хууль мэдээж оруулж ирэхгүй байх.

Тэгэхээр яаралтай, маш чанартайгаар ингэж нийтийн төлөө бас ажиллахыг энэ Нийгмийн бодлогын байнгын хорооноос шахаж ажиллана гэдгийг бас хэлье.

Сарангэрэл гишүүн санал хэлье.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Ингээд саналаа хэлээд орхиё. Анужин дарга аа саналаа хэлье. Саяын энэ Оюунчимэг гишүүний ярьж байгаа эмийн чанар,

эмийн үнэтэй холбоотой асуудлыг Байнгын хороо анхааралдаа авах ёстой. Өнөөдрийн ер нь хурлын хамгийн гол зорилго хаврын чуулганаар Нийгмийн бодлогын байнгын хороо ямар үйл ажиллагаа явуулах вэ, ямар бодлогыг тэргүүлэх чиглэлээ болгох вэ гэдэг тал дээр бид нар ярилцах нь их зүйтэй юм байгаа юм.

Үүнээс 1 удаагийн хурал хийгээд, тэр хурлаараа хэлэлцэх тухай асуудал биш. Бид нар ерөөсөө энэ маш богинохон хугацаа үлдлээ шүү дээ. Хаврын чуулган эхэллээ. Нийгмийн бодлогын байнгын хороо нийгэм рүү чиглэсэн ямар бодлого барих вэ гэдгийгээ нэлээн сайн ярилцах ёстой гэж би ингэж бодож байгаа юм.

Тэгэхээр сая эмийн чанар, Эмийн түр хороо гэж байгуулагдаад тэгээд ажлын хэсгийн ахлагч маань сайд болоод үндсэндээ энэ Түр хорооны ажил бол яваагүй. Энэ бол заавал Түр хороо байгуулж хийх ёстой ажил биш л дээ. Үүнтэй холбоотой асуудал Нийгмийн бодлогын байнгын хорооны иууд хариуцах чиглэл, иууд хариуцах сэдэв учраас энэ дээр бид нар ажлын хэсэг гаргаад энэ эмтэй холбоотой асуудлуудыг ярихгүй бол энд ахмадууд нийт иргэдийн зүгээс эмийн чанар эмийн үнэтэй холбоотой асуудлыг маш их тавьж байгаа. Энэ бол манайд хаврын чуулганы бодлогын нэг байх ёстой.

Хоёрдугаарт, ахмадын тэтгэврийн асуудал. Энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хорооны өөрийн гэсэн байр суурь байхгүй бол энэ тэтгэвэртэй холбоотой нөгөө бага тэтгэвэр нэмэгдээд 500 болоод, түүнээс илүү авч байсан хүмүүстэй ойрхон болчихсон гээд энэ гомдлуудыг бол энэ манай Байнгын хороо өөрийн гэсэн байр суурьтай, өөрийн гэсэн бодлоготойгоор бас нэг шийдвэр гаргаад, санал гаргаад Улсын Их Хурлын чуулганы түвшинд энийг ярьж, хөндөх ёстой гэсэн ийм байр суурьтай.

Гуравдугаарт хүүхдийн мөнгө. Хүүхдийн мөнгөний асуудал бол үнэхээр нийгмийн бухимдуулсан тэгээд бид нарын нөгөө ярьсан 91.99 хувь чинь эсрэгээрээ болчихоод. Бодит амьдрал дээр ийм байгаа юм билээ. Тойрогт уулзалт хийсэн хүн болгон ярьж байгаа байх. Энэ хүүхдийн мөнгөний асуудлыг бид нар яах вэ гэдгийг бас Байнгын хороо бодлогоо гаргах ёстой гэж ингэж бодож байна.

Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн хувьд ерөөсөө бүрэлдэхүүн нь болчихсон ганцхан Үйлдвэрчний эвлэлийн байгууллагын л төлөөлөл байхгүй юу. Тийм болохоор бид нар өөр бусад төрийн байгууллагын төлөөллийн тухай асуудал яригдахгүй. Энийг манайхан ойлголтоо нэг жигдэлчих ёстой юм байгаа юм.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль. Энийг манай Чинбүрэн гишүүн өнгөрсөн хугацаанд эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр их санаачилгатай ажилласан. Энэ салбарын энэ хуулийн асуудлууд үнэндээ орхигдсон байсан юм. Тэгээд тэр яамны түвшинд явахгүй байсан учраас гишүүддээ Чинбүрэн гишүүн маань Улсын Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулаад, ахлаад ингээд надад тухайлбал Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хариуцах гээд ингээд бас эзэнтэй болгож өгсөн л дөө.

Тэгээд манай шинэ сайд Чинзориг томилогдоод энэ хуулиа бид нар, яам ингээд хийгээд, тэгээд ажлын хэсгийн түвшинд хамтраад ажиллая гээд. Бид нар ойлголцсон учраас би энэ ажлын хэсгийн ахлагчаасаа татгалзаад, яамыг Засгийн газрын түвшиндээ энэ хуулийнхаа төслийг өргөн барьчих. Яагаад гэвэл эрүүл мэндийн салбарын суурь хууль гэдэг дээр бид нар ойлголцоод явсан тиймээ Чинбүрэн гишүүнээ? Тэгээд ингээд мэдээж хэрэг Засгийн газар, яам маань өргөн барьчихаар зэрэг энийг бид нар хариуцаж байсан улсууд нь ажлаа ингээд

хийгээд явах бүрэн бололцоотой гэж ингэж бодож байгаа.

Дээр нь энэ сая тогтоолын төсөл дээр 1 цаглавар гэж үзээд л, цаглавар гэж үзээд л байна. Бас бид нар энэ асуудал дээр нэлээн нэгдсэн тийм ойлголттой, тэр Монгол хэлний ангуучийг харчихгүй юу. Уг нь “цагалбар” л гэдэг юм энэ дээр “цаглавар” л гээд биччихсэн байна. Тэгээд “ыг” залгах гэж байгаа бол “А”-г нь гээдэг юм. Тийм болохоор бас энэ бичиг үсэгтэй холбоотой, алдаа дүрэмтэй холбоотой юман дээр анхаарахгүй бол бас Байнгын хорооны нэр дээр буруу, зөрүү мэдээлэл, ойлголт яваад байдаг ийм юм байгаа юм.

Тэгээд саяын миний хэлсэн зүйлүүдийг би протоколд оруулаад, нэлээн сайн бодлогын чанартай олон нийтийн зүгээс биднээс хүсэн хүлээж байгаа асуудлууд дээр Байнгын хороо хаврын чуулганаар бодит шийдвэр гаргах ёстой гэсэн ийм саналыг хэлж байна. Баярлалаа.

П.Анужин: Сарангэрэл гишүүнд баярлалаа. Манай Байнгын хорооныхон 2 гишүүн нэмж санал хэлэхээр саналаа хэлж байна. Эхлээд Содномын Чинзориг гишүүн. Ер нь бол гишүүд цаашидаа цагаа барьж орж ирээд асуулт, хариулт авах хугацаандаа нэрээ өгөөд бас дэгээ баривал сайн байна. Хоцорч орж ирээд тэгээд бүгдээрээ би хэлье, би хэлье гээд ингээд хуралдаа бас хүндэтгэлтэй хандахыг хүсэж байна. Одоо 3 нэр, 3 гишүүн асуулт асуух. 4 ч юм уу. Түрүүн бол асуулт, санал хамт явлаа гэж бас хэлсэн шүү гишүүд ээ. Одоо Содномын Чинзориг гишүүн асуулт асууна. Санал хэлэх юм уу?

С.Чинзориг: Байнгын хорооны гишүүдийнхээ амгаланг айлтгая. Би байнгын хорооны хуралдаанд хугацаа алдаж орж орж ирээгүй л дээ. Тэгээд явцын дунд, хэлэлцүүлгийн дунд гишүүд санал хэлж байгаа учраас бас санал хэлье гээд л гар өргөчихлөө.

Би 3 сарын 28-нд нэг мэдээлэл оруулдаг юм уу гэсэн бодолтой байх юм дарга, гишүүд зөвшөөрвөл. Эрүүл мэндийн сайдаар томилогдоод 2 сар боллоо. Тэгээд болж байгаа ч юм байна, болохгүй ч байгаа юмнууд бол байна. Тэгэхээр ер нь эрүүл мэндийн салбарын өнөөгийн байдал нөхцөл байдал ямаршуухан байгаа гэж дүгнэж байгаа юм. Цаашидаа Байнгын хорооны дэмжлэгийг юун дээр нь авах вэ? Ямар хууль тогтоомжид өөрчлөлт оруулах вэ? Саналуудаа нэг яриад нөгөө цахимын эрүүл мэндийн асуудал бас нэлээн хүнд хүндрэлтэй гацааны байдалтай орчихсон. Гүйцэтгэлийн санхүүжилт болж байгаа ч юм байна, болохгүй ч юм байна. Тэр дээр нь би бас жаахан өртгийн тооцоолол, өөрчлөлт хийгээд тарифаар нь жаахан өөрчлөлт хийгээд жаахан засаж сайжруулъя гээд ярьж байгаа юмнууд байна.

Эмтэй холбоотой асуудал дээр бас ярьж байгаа, судалж байгаа. Гааль, татвартай хамтраад ажиллаж байгаа юм байна. Ер нь бол энэ дээр энэ эмийн чанар үнэ тэгээд дээр нь энэ замбараагүй хэрэглээтэй болчихсон асуудлууд байна. Онцгой нөхцөл байдал үүссэн үед энэ улсын нөөцийн эм тарианы асуудлыг яаж зохицуулах вэ энэ тэр гээд асуудлууд нэлээн юмнууд байгаа юм байна.

Тийм учраас ерөнхийдөө би эрүүл мэндийн, Нийгмийн эрүүл мэндийн хууль, Эмийн тухай хууль, Тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал, Дархлаажуулалтын хуульд өөрчлөлт оруулах гээд ийм 4 хуулийг бол ямар ч байсан хаврын чуулганд оруулж хэлэлцүүлнэ гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа. Энэ 4-ийг оруулна.

Цаана нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламжийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тэгээд Чинбүрэн гишүүн дээр байгаа Донорын хууль, нөгөө эд эс, эрхтэн шилжүүлэх тухай хууль энэ тэр гээд ийм хуулиуд. Ерөнхийдөө Ерөнхий сайдтай, Их Хурлын даргатай бол эрүүл мэндийн

салбарын багц хуулиудыг оруулна гээд ингээд урьдчилсан байдлаар бол яриад ойлголцсон юм байгаа.

Тэгэхээр би ирэх 7 хоног гэхэд жаахан бэлтгэл юмнууд хэрэгтэй болов уу гэж бодож байгаа. 28-ны 2 дахь өдөр Байнгын хорооны хурал хуралдвал сайдын мэдээлэл нэлээн сайн бид нар юмаа бэлдээд, тэгээд болж байгаа юм, болохгүй байгаа юмыг нь шийдэх гарц гаргалгаа гэсэн юмнуудаа бид нар яриад тэгээд Байнгын хороон дээрээ сайн бас ойлголт өгье. Та бүхнийхээ бас саналыг ч бас сонсъё гэсэн бодолтой.

Ялангуяа гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой асуудал дээр бид Сангийн яамтай хамтраад ажлын хэсэг гаргаад, зарим өртгийг нь тооцоолж дахиж хянах, тарифаа нь өөрчлөлт оруулах, ялангуяа анхан шатны сумдын Эрүү мэндийн төв дээр бас тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, тарифыг нь нэмэх замаар санхүүжилтийг нь нэмэгдүүлэх тэнд хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжийг нь бүрдүүлэх эд нар бас зөндөө юм байна.

Тэгэхээр би бас ингээд сайд гээд ингээд өөрөө ганцаараа тэнд юм нухаад тэгээд яваад байх нь зовлонтой. Тийм учраас бас мэргэжлийн Байнгын хороон дээр танилцуулж бас та хүүхдийнхээ бас санал бодлыг сонсъё гэсэн бодолтой байна. Тэгээд сонсчих юм бол би 4 сараас бараг тэгээд тэр ядаж л гүйцэтгэлийн санхүүжилтийнхээ тарифт өөрчлөлт оруулах юмнуудаа 4 сарын 1-нээс хэрэгжүүлчихье гэсэн бодолтой байх юм. Ийм нэг санал байна. Тэгээд гишүүд зөвшөөрвөл би 28-ны хурлаар мэдээлэл оруулъя. Тэгээд жаахан цаг гаргаад, жаахан цаг тавиухан тавиад тэгээд сайн ярилцаж өгвөл их сайн байна.

П.Анужин: Чинзориг сайдад баярлалаа. Сая энэ хоцорсон асуудалд Чинзориг сайдыг хамруулж хэлээгүй юм шүү. Чинзориг сайд маань хамгийн

түрүүнд бас хуралдаа ирчихсэн байсан. Мөн энэ эрүүл мэндийн салбартай холбоотой 4 чухал хуулийг маш богино хугацаанд бас салбарын сайд маань өөрөө манлайлж ингээж хийж байгаа явдалд бас Байнгын хорооны зүгээс талархаж байгаагаа бас хэлье.

3 сарын 28-ны өдөр та бас энэ танилцуулах санал хэллээ. Сая энэ хөтөлбөрийг бол бид нар шалгалаа. Тэгээд 3 сарын 28-нд боломжтой юм байна.

Дээрээс нь бас энэ асуудлыг сонсохыг Байнгын хорооны гишүүд маань дэмжсэн учраас Чинзориг сайдаа 3 сарын 28-ны өдөр бид нар Байнгын хороон дээрээ энэ эрүүл мэндийн салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдэх ёстой гарц гаргалгааг нь гаргах ёстой энэ асуудлаа дэлгэрэнгүй сонсож ярилцъя гэсэн Ингээж тийм төлөвлөгөөнд бол тусгалаа. Чинзориг гишүүн энэ боломжтой юм байна. Чинзориг сайдад баярлалаа.

Одоо 3 гишүүн байгаа юм байна. Манайхан яг албан ёсоор энэ санал хэлэх гишүүдийн нэрийг авчихъя. Чинбүрэн гишүүн, Одонтуяа гишүүн, Бейсен гишүүн гурав санал хэлнэ. Дараалал нэрсийг нь оруулчих тийм ээ. Чинбүрэн гишүүн саналаа хэлье.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Та бүхэнд энэ хаврын чуулганы өдрийн мэндийг хүргэе. Би их товчхон гол асуудалдаа хандъя гэж бодож байна. Ер нь манай Байнгын хорооны зайлиггүй энэ хугацаандаа шийдэх ёстой зүйл бол эмийн чанарын асуудал байгаа.

Тийм учраас эмийн чанарын асуудлыг эм эмнэлгийн хэрэглэгдэхүүний хууль бол 21 онд орж ирээд ажлын хэсгийг нь би өөрөө ахлаад 8 сар ажилласан. Асар их ажил орсон. Тэгээд нэлээн цэгцлээд Засгийн газарт буцаагаад өгчихсөн. Засгийн газар нөгөө үндсэн үзэл санаа нь өөрчлөгдсөн учраас татаж аваад, одоо

бол нэлээн тийм ойрхон болчихсон гэж харж байгаа юм.

Тэгэхлээр яг энэний өмнө бид эмийн чанарын нөхцөл байдлаа зах зээл дээр ер нь ямар байгаа талаар ер нь бид Түр хороо цаашаа ажиллаж чадахгүй болох юм бол Байнгын хороон дээр ажлын хэсэг нэн яаралтай ажиллаад, хууль орж ирэхэд бид нөхцөл байдлаа өөрсдөө мэддэг болчихсон байвал их сайн байгаа юм. Өнөөдөр та бүхэнд тараагдсан үндэсний аюулгүй байдлын тэр ном дээр хамгийн чухал яригдаж байгаа зүйл бол энэ антибиотикт тэсвэртэй байдал байхгүй юу. Энэ өөрөө эрүүл мэндийн салбарыг үнэгүйдүүлж байгаа асар их зардал болж байгаа. 7 хоног сайн эм антибиотикоор эмчилчих байсан хүнийг л одоо 21 он эмчлээд байгаа байхгүй юу. Хамаг мөнгө нь дуусаад байгаа юм. Тэх, тэгээд дасал болчихно. Тэгээд эдгэрэхгүй бүр.

Тийм учраас бид ерөөсөө энэ асуудлыг энэ 24 оныхоо чуулгандаа яаралтай Байнгын хороо маань энийг бүр шийдээд, гаргаад, асуудлыг нь бүүр тавиад хууль, эрх зүйн талаас нь шийдчихсэн байх нь нэн шаардлагатай учраас би таныг ямар нэг байдлаар Байнгын хорооны дарга, Түр хороо ч байна уу, ажлын хэсэг ч байна уу энүүгээрээ ерөөсөө нэн яаралтай энэ ажиллагаагаа явуулъя. Энэ дээр та бүр идэвх санаачилга гаргаж өгөөч гэж хүсэж байна. Баярлалаа.

П.Анужсин: Чинзориг гишүүний микрофоныг өгье.

С.Чинзориг: Тэгэхээр Байнгын хороо ажлын хэсэг гаргах уу? Би гайхлаа. Би Шадар сайдтай яриад ер нь эмийн үнийн асуудал, чанарын асуудалтай холбоотой асуудал дээр Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, манай яам, эмийн агентлаг хамтраад тийм томоохон Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газраар ахлуулсан тэгээд Шадар сайд бид нарын хамтарсан

удирдамжтай тийм шалгалт эхлүүлж байгаа юм. Энэ 7 хоногоос.

Тэгэхээр тэрийг явцыг нь бас Байнгын хороон дээр сонсох уу? Зэрэгцээд Байнгын хороогүй ажлын хэсэг гаргаад явуулах уу? Тийм нэг асуудал байгаа. Тэрийг нэлээн бас сайн хийж өг гээд. Тэгээд би бас татвар, гаалийнхантай бас нэлээн хэрүүл хийж байна. Тэгээд тэр хамтарсан ажлын хэсгийн дүнг нь бас Байнгын хороон дээр нэг сайн яриад яах уу? Үгүй бол Байнгын хороо зэрэгцээд ажлын хэсэг гаргах уу? Тэр бол Байнгын хорооны л эрхийн асуудал л даа.

Бид бол тэр агентлагтай Шадар сайдтай хамтарсан тушаал гаргаад тийм бас шалгалт энэ 7 хоногоос эхлүүлчих нэлээн өргөн далайтай юм хийгээдэхье. Тэгээд тэр ч гэсэн бас тэгээд бид нар болохгүй байгаа юм зөв оношлох хэрэгтэй. Хоёрдугаарт, хууль гаргах. Хамгийн гол нь эмийн үнийг тогтоох, тогтвортой болгоход бас аргачлалууд бий. Татвар гаальтай бас нэлээн ярьж байгаа. Татвар дээр ч бас нэлээн бид хармаар, анхаармаар юм маш их байгаа юм байна лээ.

П.Анужсин: Чинзориг сайд маш чухал санал хэллээ. Эмийн асуудал бол өрх бүрийн бараг тулгамдсан асуудал болчихоод байгаа. Тэгэхдээ Байнгын хорооны гишүүд маань нэг зүйлийг ойлгож байгаа. Энэ Түр хороо тайлангаа хий, тайлангаа тавьж 8 Улсын Их Хуралд тайлангаа тайлагнаснаар Түр хорооны ажил, энэ хугацаа дуусаж бид нар Байнгын хороон дээрээ эмийн асуудлыг эрхлэх ажлын хэсгийг байгуулах асуудал чинь түүний дараа яригдах байхгүй юу.

Тэгэхээр та бүхэн маань ойлгож байгаа. Түрүүн Оюунчимэг гишүүн маш чухал санал хэлсэн. Эмийн асуудал чинь зүгээр ажлын хэсгээр зогсох асуудал мөн үү. Түр хороон дээрээ байх нь зөв гэж.

Гэтэл Түр хороо маань та ч түрүүн бас үгэндээ хэлсэн. Ерөөсөө амжилттай

ажиллаж чадаагүй, олигтой ч хуралдаагүй. Тэгээд Түр хороо нэртэй. Тийм учраас бодлогын хувьд Байнгын хороон дээрээ нэгтгэж цаашаа энэ асуудлыг Байнгын хороо нь өөрөө манлайлал үзүүлж, мэргэжлийн эмч энэ асуудлаар манлайлал хийдэг гишүүд нь өөрсдөө ахалж, ялангуяа энэ эмийн асуудлууд дээр Чинбүрэн гишүүн, тэгээд Оюунчимэг гишүүн, Сарангэрэл гишүүн гээд маш ийм манлайлалтай ажилладаг гишүүд маань байгаа.

Тэгэхээр Байнгын хороон дээрээ татаж энэ асуудлыг ер нь цааш нь аваад явбал ямар вэ гэсэн ийм чиглэл байгаа юм гишүүд ээ. Энийгээ бас та бүхэнд хэлэхийг хүсэж байна.

Энэ эмийн чанарын асуудал дээр мэдээж Байнгын хороо бол байнгын анхаарал тавьж ажиллана. Гэхдээ энэ өөрөө нөгөө бүтэц, зохицуулалтын хувьд Түр хороо байгуулагдчихаад байгаа учраас Түр хорооны статус нь одоо бид нар бас шийдэгдээгүй байгаа учраас ийм байгаа гэдгийг Чинбүрэн гишүүн бол мэдэж байгаа.

Чинзориг гишүүн бол маш чухал асуудлыг та эхлүүлчихсэн байна. Энэ шалгалт гэдэг маш чухал шүү. Энэ ямар түвшиндээ хэн явуулах нь чухал биш салбарын яам манлайлал үзүүлээд үүнийг хийгээд явж байгаа гэдэг нь чухал. бид нар Улсын Их Хурал дээр энэ эмийн Түр хорооны тайланг сонсох асуудлыг бол бид нар түрэгдэх асуудал дээр санаа тавьж ингэж ажиллана гэдгийг хэлье.

Одоо Салдангийн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Та бүхэндээ бас хаврын чуулганы нээгдэж байгаа мэндийг дэвшүүлье. Тэгээд энэ 3,4 сард бас үр бүтээлтэй бас сайхан ажиллах байх гэж итгэж байна.

Би энэ цаглавартай холбоотой хэд хэдэн санал хэлэх гэсэн юм. Энэ Хүүхэд

хамгааллын хууль гээд орчихсон байгаа. Энэ чинь нөгөө манай эмэгтэй гишүүдийн бүлгээс санаачилсан хууль байхгүй юу. Тэгэхдээ бид нарын хууль хэлэлцэх эсэх нь дэмжигдээд нөгөө Засгийн газраас оруулж ирж байгаа хуультай хамтатгаж хэлэлцэхийг нь эмэгтэйчүүд зөвшөөрсөн шүү дээ. Тэгээд тэр хууль хаана байна? Чухамхүү өнөө, маргаашгүй оруулж ирнэ. Та нар больчхооч л гэсэн. Бид нар хэрвээ ингэж удах байсан бол аль дээр батлуулчихсан бол өнөөдөр янз янзын энэ асуудал гарахгүй.

Тэгээд нөгөө эмэгтэй гишүүд дуугарахгүй байна гээд. Бид нар чинь энэ хуулиа бодлоо батлуулах хэрэгтэй байна л даа. Энийг Байнгын хорооны дарга анхаараад яамнаас нь мэдээлэл авч өгөөч. Бараг бэлэн байгаа л юм ярьсан. Тэгээд энийг хамтатган хэлэлцмээр байна.

Хоёрт энэ Хүүхэд хамгааллын хууль дээр би бас өчигдөр танд даргын дэргэдэх хурал дээр хэлж байсан. Энэ хүүхдийн цахим халдлагаас хамгаалах талаар ордонд нэг хэлэлцүүлэг хий хийх санал гаргасан байгаа. Энэ ямар учиртай юм бэ гэхээр UNICEF-ээс жил болгон дэлхийн бүх улс орнуудад гаргадаг хүүхдийг цахим халдлагад хэрхэн өртөж байгаа талаар судалгаанууд гарсан байгаа. Энэ дээр Монгол Улс хамгийн аюултай түвшинд хүрчихсэн байгаа. Тэгэхээр энэ хуулиа ч гэсэн бид нар яриад батлуулбал одоо тэр цахим юу руу нь бас оруулах ийм боломж нээгдэнэ. Тэгэхээр та өдрөө харж байгаад UNICEF-ийнхэнтэй бас ярьж байгаад хамтраад энэ цахим халдлагын нэг хэлэлцүүлэг хийчихвэл зүгээр байна.

Гэр бүлийн тухай хууль 2013 онд л орж ирээд л тэгээд л баахан ажиллаад буцаад татагдсан. Одоо бараг 10 жил болж байна. Тэгэхээр энэ Гэр бүлийн тухай хуулиа яах юм бол? Та энэ холбогдох яам руу нь бичиг сачиг өгөөч. Тэгээд энэ чинь 99 оны хууль болохоор тэнд нэг аюултай заалт байдаг байхгүй юу. Нөгөө хамтран амьдрагч гэдэг заалт

байдаггүй. Тэгэхээр одоо энэ хамтран амьдраад байгаа хүмүүс чинь дандаа энэ хүүхдийг зодох, нүдэх, хүчирхийлэх тэгээд шүүх дээр дандаа хуулийн юунаас болоод энэ хүмүүс чинь гэм зэмгүй өнгөрөөд байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг цэгцлээд, Хууль зүйн байнгын хороотой хамтраад энэ гэр бүлийн хуулиа ер нь батлах зүйтэй. Мөн Эх нялхсын хууль Чинзориг сайдаа, Чинзориг сайдаа танд хандаж байна. Энэ Эх нялхсын тухай хууль гэж ер нь тусдаа орж ирэх юм уу, яах юм бол? Энэ талаар та бас нэг мэдээлэл өгөөрэй. Сая эмэгтэй парламентчидын уулзалт дээр Мөнхөө гуай байнга ярьдаг юм. Эх нялхсын л хуультай болох ёстой гээд. Тэр нь яаман дээр бэлэн л байгаа юм шиг байсан. Энийг та яриарай.

Энэ аж ахуй эрхлэгч эмэгтэйчүүдийн эдийн засаг оролцоо энэ их чухал болчоод байгаа юм. Яагаад гэхээр Үндэсний статистикийн мэдээгээр ерөөсөө эмэгтэйчүүдийн ажил эрхлэлт чинь бараг 20 функцээр буучхаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ дээр бид нар бүр онцгой анхаараад, жоохон ажлын хэсэг гаргаад ажилламаар л санагдаад байгаа юм.

Яагаад гэхээр бидний өргөн барьсан юу чинь бас тэн дээр зөндөө нэмэлтүүд орохгүй бол бас түүхий байгаа. Тэгэхээр энэ дээр нэлээн олон чухал заалтуудыг бас оруулчихмаар юм байна лээ. Өчигдөр Үйлдвэржилтийн байнгын хороон дарга бас их аятайхан санал гаргасан. Тэр оёдлын төхөөрөмж, оёдлын материалыг гааль НӨАТ-аас чөлөөлөх юм бол ерөөсөө тэнд салбарт дандаа 90 хувь нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа гэсэн ийм байгаа.

Сая энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал нэлээд бас байна. Би бас сая тойргоороо яваад уулзлаа. Тэгээд энэ дээр яах вэ би Жаргалмаа гишүүнтэй хамтарч байгаад саналуудаа бэлдээд өгье. Энэ чиглэлээр ямар нь эрх зүйн

шинэчлэл хэрэгтэй байна, ямар нь зүгээр дүрэм, журам юм гэдгийг бас би ингээд хийгээд өгье гэж бодож байна.

П.Анужин: Одонтуяа гишүүндээ баярлалаа. Хүүхэд хамгааллын хууль дээр бид нар шахааж бол бас анхаарч салбар яаманд байнгын хэлж байгаа. Энэ хууль ямар түвшиндээ явж байгаа юм, яаравчлан бас Улсын Их Хурлаар оруулж ирэх тухай бид нар байнга хэлж байгаа.

Хүүхдийн цахим халдлагын тухайд та бас сая маш чухал санал хэллээ. Бид нар энэ асуудлыг авч үзээд, энэ хэлэлцүүлгийг бол бас ойрын хугацаанд зохион байгуулъя гэдгийг бас танд хэлье.

Энэ Гэр бүлийн хууль бол Хууль зүйн яам манлайлж ажиллаж байгаа, боловсруулж байгаа. Тийм Хууль зүйн яам боловсруулж байгаа. Тэгээд Хууль зүйн яамнаас бид нар бас энэ Гэр бүлийн хуулийн явцыг асууж байгаа. Ойрын хугацаанд бол бас боловсруулалтаа дуусгаж ингэж бас манай Байнгын хороонд мэдээлэл өгнө гэсэн ийм үйл явцтай байгаа.

Эх нялхсын эрүүл мэндийн тухай хууль бол бид нар Эрүүл мэндийн тухай багц хууль маань өөрөө орж ирэх гэж байгаа учраас эх нялхсын энэ эрүүл мэндийн асуудал бол багц хуульдаа тусгагдаад явчихна. Гэхдээ Байнгын хорооны дэргэд Эх нялхсын эрүүл мэндийн хууль хэрэгжилтийг хангах ажлын хэсэг байгуулагдаад миний бие бас ахлаад ингээд тодорхой хугацаа өнгөрч, тодорхой үр дүнд хүрээд ажиллаж байгаа гэдгийг та мэдэж байгаа.

Ер нь ингээд энэ манай Байнгын хороон дээр яригдаж байгаа ихэнх асуудлууд өөрөө эрүүл мэндийн суурь асуудалтай холбогддог учраас энэ эрүүл мэндийн хууль өөрөө маш чухал байгаа. Ийм учраас ойрын хугацаанд бол Эрүүл мэндийн яам, салбарын яам маань энэ хуулийг оруулж ирнэ. Шинэ сайд маань

бас энэ дээр маш манлайлалтай ажиллаж байгаа гэдгийг бас танд хэлье. Баярлалаа.

Одоо Буланы Бейсен гишүүн асуулт асуугаад, санал хэлээд энэ санал, асуулт дуусаж байна.

Б.Бейсен: *Энэ хаврын чуулганы нээлтийн баярын мэнд хүргэе. Бас түрүүн хурал давхацчихаад бид нар оройтоод яачихлаа уучлаарай. Энэ эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт шалгалтын түр хороо гээд байгуулагдсан. Бүр шинжээчдийгээ томилсон шүү дээ бид нар. Шинжээчийн саналыг нь авсан. Одоо энийг цаашаа өргөжүүлэн ажиллах шаардлагатай байх. Сая Оюунчимэг гишүүний саналаар. Шинжээч нарын юу хийсэн тэрийг бас сонсьё л доо. Түрүүн бас тайлан тавина гээд Учрал гишүүн сайд болчихоод тайлан гарахгүй байгаа.*

Та нар бид нарыг эрүүл мэндийн салбарт өчнөөн жил ажилласан энэний талаар ер нь сайн мэдэж байна. Бид нараас бас юм асууж бай л даа. Энэ эмийн талын асуудал ноцтой асуудал их байгаа. Сая хөдөө сумуудаараа яваад ирлээ. Сайдаа, сайд би сая хөдөө сумдаар яваад, би насаараа эмч хийсэн хүний хувьд байна шүү дээ. Эмнэлгийн дарга ч хийлээ, газрын дарга ч хийлээ. Сумуудын эмнэлгээр ороод аптека болгоноор ороод шалгасан сая би. Эм байхгүй байна шүү. Дутагдалтай байна, үнэтэй байна.

Нөгөө талаар чанаргүй эм чинь яг тэнд байж байна. Энэ эмийн тендерийн асуудлаа бас хөрвөөд хаячихдаг. Авах эм нь байхгүй нөгөөдүүлийн. Зарим сум дээр чинь эм байхгүй өөрсдөө эмийг гэрээр авчраад эмчилгээ хийлгэж байна. Аптекийн асуудал дээр онцгой анхаараад, эмийн асуудал дээр анхаарахгүй бол ард иргэд чинь сөхрөөд дуусаж байна шүү дээ ерөөсөө. Хотод болдог л байх. Хөдөөд очихдоо бүр үнэтэй очиж байна шүү дээ. Энийг нэг анхаараач. Ард иргэдийн ярьж байгааг. Тэр хөнгөлөлттэй эмийг авч чадахгүй байна. Хөнгөлөлттэй эм нь ч байхгүй байна.

Нөгөө талаар сумын тэр салбарын эрхлэгч нар нь илүү орон тоо авчихсан. Нөгөө ноднин КОВИД-ын мөнгийг чинь зөв зарцуулаагүй. Илүү орон тоон дээр төсвөө зарцуулчихсан ийм байдалтай байна шүү дээ. Тоног төхөөрөмж юу ч байхгүй байна эмнэлгүүд дээр. Нөгөө гүйцэтгэлийн санхүүжилт чинь будаа түүн дээр. Энийг анхаарахгүй бол байна шүү дээ. Энэ асуудал биш. Нэг сум дээр очсон чинь 1 Хятадын зүрхний бичлэг аппарат, био химийн бусад аппарат байхгүй нэг ч юм байхгүй. Яаж бид нар цаг хожих юм, Шалгуур үзүүлэлтийг нь өндөр тавьчихсан. Одоо анхан шатны юм уу, сумын эмнэлгүүд дээр 3 дугаар шатлалын эмнэлэг дээр хийгддэг юмнуудыг нь шалгуур тавьчихсан.

Нөгөө талаар нарийн мэргэжлийн эмч тийм аппарат тоног төхөөрөмжүүдийг хүн эмчилдэг. Хатгааг эмчилж байна. Рентген аппарат байхгүй гээд эндээс юуг нь шууд хасаад хаячихдаг. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтыг нь хасаад хаячихдаг. Яах аргагүй хатгааг эмчилж байна уу? Эмчилж байна. Тэгээд санхүүжилтээ авч чадахгүй байна. Энэ дээр бас Шинэзориг сайд эргэж хараад бас энэ шалгуур үзүүлэлт сумууд дээр энийг анхаарч үзэхгүй бол үнэхээр болохгүй юм байна ерөөсөө. Энэ талаар ярих гэсэн юм. Ъ

Нөгөө талаар энэ тэтгэврийн зөрөөг ярьж байна. Хөдөөгийнхөн бүгд тэрийг ярьж байна. 40 хэдэн жил ажиллачхаад сая нэмэгдээд 500 болсон. Юманд хүрэхгүй байна, юуны үнэ өндөр байна гээд энийг ярьж байна. Энийг бас хэлэлцэх тал дээр Анужин даргын энэ хаврын чуулганаар бас ярихгүй бол болохгүй юм шиг байна.

Дараа нь энэ хотод ч гэсэн, хөдөө ч гэсэн сувлагч олдохоо байсан байна. Цалингаа голсон сувлагч, асрагч нар гадагшаа явж байна. Гүйцэтгэлийн санхүүжилтээр одоо 2 сая 500 авч байна

гэдэг чинь худлаа юм байна. Очоод үзээрэй 900 хэднээс бүр олон жил 30, 40 жил ажилласан улсууд чинь 1200000 хамгийн их.../минут дуусав./

П.Анужин: Бейсен гишүүнд 1 минут өгье.

Б.Бейсен: Тийм учраас энэ цалингийн асуудал дээр анхаарахгүй бол үнэхээр гадаадад сувилагч нарын цалин 3 сая байдаг юм байна. Тэгээд тийшээ явж байгаа юм байна. Үнэхээр эмнэлгийн ажилчдын цалин бага байна шүү дээ. Энийг нэмэхгүй бол болохгүй нь. Сүлжээг нь нэмж байгаад гүйцэтгэлийн санхүүжилт дээр нь нэмж өгвөл гүйцэтгэлийн санхүүжилтээр олсон мөнгөөр эмнэлгүүд өөрсдийнхөө тоног төхөөрөмж авчих боломж байгаа юм байна.

Энийг сайдаа судалж хэлээч. Танаас урьд нь юунд ажиллаж байсан энэ нийгмийн даатгалын санхүүжилтийн талаар сайн мэдэх байх. Энэ дээр нэлээн анхаарч ажиллах саналтай байна гэж хэлмээр байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

П.Анужин: Бейсен гишүүнд баярлалаа. Үнэ цэнтэй саналууд ялангуяа энэ эрүүл мэндийн салбартай холбоотой асуудлууд дээр Бейсен гишүүн үргэлж бас үнэ цэнтэй санал хэлдэг. Нэгэнт бас өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд бас салбарын сайд маань байгаа учраас хэлсэн саналуудын 2 нь салбартай холбоотой асуудал байгаа учраас сая энэ эм, эмч, сувилагч, эмнэлгийн ажилтны цалингийн тухай асуудал байна. Эмийн чанарын тухай асуудлууд дээр Чинзориг сайд хариулт өгье.

Сая нэг асуусан асуулт нь энэ тэтгэврийн зөрөөг арилгах тал дээр нийгмийн даатгалын багц хууль дээр яаж шийдэж байгаа юм бэ гэж.

Бид нар хуулийн төслийг энэ танилцуулах явцад хэлж байгаа юм. Энэ

зөрүүг бол бид нар арилгахын тулд ямар ч байсан энэ тэтгэврийг жил бүр бид нар энэ тэтгэвэр тогтоодог энэ итгэлцүүрийг бол жил бүр шинэчлэх, инфляцтай уялдуулж жил бүр бид нар шинэчлэн тогтоож байх энэ чухал бас зүйл заалтуудыг оруулж байгаа.

Мөн өөр тогтолцооны өөрчлөлтүүдийг бас энэ хуулийн төсөлд тусгасан байгаа гэдгийг та нар мэдэж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл хэлэлцэгдэх явцад бас таны энэ асуултуудад илүү бас тодорхой хариулаад явна гэдгээ Бейсен гишүүнд хэлье.

Ингээд Бейсен гишүүний асуултад Чинзориг сайд хариулна.

С.Чинзориг: Бейсен гишүүнтэй санал нэг байна. Энэ гүйцэтгэлийн санхүүжилтийнхээ аргыг бид нэлээн эргэж харахгүй бол бас болохгүй байгаа юм. Ялангуяа хэвтэн эмчлүүлээд л байвал сайн, өндөр өртөгтэй оношилгоо шинжилгээ л хийгээд байвал сайн, өндөр өртөгтэй мэс засал хийгээд байвал сайн гэсэн яг ийм 3 үйлчилгээнүүдтэй манай эмнэлгүүд ялангуяа энэ төв суурин газар байгаа нэгдсэн эмнэлгүүд уралддаг болчихсон юм байна лээ. Нөгөө амбулаторийн үйлчилгээ байхгүй болчихсон, нийгмийн эрүүл мэнд анхан шатны тусламж, үйлчилгээ байхгүй болчихсон. Жаахан асуудал байна.

Тийм учраас бид нар нэлээн судалж байгаа. Сангийн сайдтай ярьж байгаа ингээд тарифын өөрчлөлт бол хийнэ. Би тарифын өөрчлөлт хийх замаар ялангуяа анхан шатны эмнэлгүүд дээр үзүүлэх тусламж, үйлчилгээг нь нэмэгдүүлье. Тэгээд санхүүжилтийг нь нэмэх замаар сумын эрүүл мэндийн эмч нарын цалинг нь 30 хувиар нэмэгдүүлэх эх үүсвэр гаргая гээд ингээд ажиллаж байгаа. Би 28-нд танилцуулга хийхдээ энийг та бүхэндээ хэлээд, тэгээд та бүхнээсээ бас санал бодлыг нь сонсоод, боловсронгуй болгох чиглэл ажлыг. Би урьдчилсан байдлаар энэ

санхүүжилттэй холбоотой Даатгалын ерөнхий газартай холбоотой асуудал дээр 4 чиглэл өгөөд 3 сарын 1-нээс өөрчлөлт оруулсан гэдгийг бас гишүүддээ мэдээлэл бас хэлье гэж бодож байна.

Нэг дэх асуудал нь хөнгөлөлттэй нөхцөлөөр олгодог эмийн хөнгөлөлтийн хувийг нь бас нэлээд бууруулчихсан байна. Тийм учраас бол 3 сарын 1-нээс энэ хөнгөлөлтийн хувийг нь хуучин байсан хэмжээнд нь хүргэн нэмэгдүүлж, 3 сарын 1-нээс олго гэдэг ийм чиглэл өгөөд, Даатгалын ерөнхий газар энэ чиглэлээр бодлого зохион байгуулалтаа өөрчлөлт аваад хийж байгаа өөрчлөлт гарах байх гэж.

Хоёр дахь асуудал нь хөдөөгийн ахмад, ялангуяа багийн, сумын, сумын, хөдөөгийн баг дээр аж амьдарч байгаа ахмадууд сар болгон 60-аас дээш насны ахмадуудын ялангуяа сар болгон сумын төв орж хурууны хээгээ уншуулж байж энэ хөнгөлөлттэй эм гэдэг нь дэндүү их чирэгдэлтэй байна. 60-аас дээш насны ахмадууд сар болгон сумын төв шогшиж орж хурууны хээ уншуулдгийг нь болиулъя. Харин багийн эмчийнх нь жороор нь тэр эмийг нь тэр ах дүү нь байна уу, хүүхэд нь байна уу яваад авчраад өгдөг. Тэр нөхцөлийг нь бүрдүүлж өг гээд ингээд 3 сарын 1-нээс энэ хэрэгжиж байгаа юм.

Хоёр чиглэлийн санхүүжилтийн юман дээр нь би бас жаахан Даатгалын ерөнхий газар дэндүү та нар хатуу, бараг харгис гэж хэлэхэд цаашаа юм гэж загнаж байгаад өөрчлөлт оруулж байгаа юм.

Нэг дэх асуудал нь хүн л юм болсон хойно нөгөө эмнэлгийн байгууллагуудын санхүүгийн улсууд чинь Даатгалын ерөнхий газар нэхэмжлэлийг нь гаргаад нөгөө шивж өгөхдөө бас алдаа гаргадаг. Гаргасан алдааг нь ерөөсөө засах боломж олгодоггүй. Буруу шивсэн бол буруу шивсэн бандан тас гээд хаагаад санхүүжилтийг нь тэр чигээр нь зогсоож байгаа юм. Энэ бол дэндүү бүдүүлэг.

Тэгэхээр энэ алдаагаа буруу шивсэн бол тэр алдаагаа засдаг, ядаж сарын хугацаанд засах гэхээ байг ядаж 48 цагийн дотор тэр буруу шивсэн бол тэр алдаагаа засаж залруулдаг энэ нөхцөл боломжийг нь бүрдүүлээд ингээд энэ 3 сарын 1-нээс хэрэгжиж эхэлж байгаа юм.

Хоёр дахь асуудал нь Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар эмнэлгүүдтэй 3 жилийн хугацаатай санхүүжилтийн гэрээ байгуулдаг байна. Гэхдээ энэ 3 жилийн хугацаанд гэрээ байгуулаад ажиллаж байгаа бол энэ жилдээ манайх шинэ оношилгооны тоног төхөөрөмжтэй болоод, боловсон хүчинтэй болоод, шинэ төрлийн оношилгоо үйлчилгээ, шинжилгээ хийдэг болсон бол шинэ төрлийн тусламж үйлчилгээ үзүүлдэг болсон бол 3 жилийн санхүүжилтийн гэрээнд алга гээд гүйцэтгэлийн санхүүжилтийг нь өгөхгүй байгаа юм байна лээ.

Тийм учраас бол энэ 3 жилийн гэрээтэй ч гэсэн энэ хугацаандаа бас шинэ оношилгоо, шинжилгээ, тусламж үйлчилгээ бий болгосон бол тэр санхүүжилтийг нь олгодог бай гэсэн ийм дүрэм 4 чиглэлээр өөрчилж ямар ч байсан Ерөнхий газар дээрээ чиглэл өгөөд ингээд засуулаад явж байгаа. Үлдэж байгаа нэлээн томоохон асуудлуудыг нь би 28-нд Байнгын хороон дээр ярихдаа та бүхэндээ танилцуулж саналыг чинь аваад, тэгээд ингээд засъя гэсэн. Ямар ч байсан ийм 4 чиглэлийн өөрчлөлт оруулаад жаахан бас боловсронгуй болгох. Ядаж уян хатан болох ийм юм хийгдэж байна.

П.Анужин: Бейсен гишүүн 1 минут тодруулъя.

Б.Бейсен: Дуулгачихъя. Сая сумуудаар явж байхдаа би асуухгүй юу сумууд дээр алсын дуудлага их байдаг байхгүй юу хөдөөгийн дуудлага. Тэгээд тэрийг чинь 75 километр хүрэхгүй бол нэг талын санхүүжилтийг нь өгнө гэдэг юм байна. Эмнэлэгт тийм юм байхгүй, нөгөө

ард иргэд нь бензин хийгээд явж байна. Энийг тэр шалгуур дээр нь бас тэгээд оруулчихсан байна.

Жишээлбэл 10, 20 километр газар байна шүү дээ. Нэгэнт тэр юм олгодоггүй та нар аваад ир гэх юм уу ингээд явуулдаг юм байна. Тэр асуудал дээр бас нэлээн. Алсын дуудлага сумууд дээр байнга байдаг. Ерөөсөө малчдын дуудлага дээр.

П.Анужин: Бейсен гишүүнээ түрүүн бас Чинзориг сайд маань өөрөө санал гаргаад 3 сарын 28-нд Байнгын хороон дээрээ энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотой гарч байгаа бэрхшээлүүд, эрүүл мэндийн тулгамдсан асуудлын талаар дэлгэрэнгүй танилцуулга хийхээр болсон. Энэ үед бас таныг саяын асуудлуудыг бас тодруулж асуугаарай гэж хүсье.

Түрүүн бас Сарангэрэл гишүүн их чухал санал хэлсэн. Бид нар нэгэнтээ энэ хаврын чуулганаар хэлэлцэх асуудлуудын цаглаврыг хэлэлцэж байгаа учраас бүх гишүүдийнхээ саналыг бас тодорхой яриулж ингэж бас хэлэлцэх нь зүйтэй гэдэг саналыг гаргасан учраас бүх гишүүдийн бас санаж бодож байгаа, хаврын чуулганаар хэлэлцэх ёстой гэж үзэж байгаа асуудлуудыг хэлүүлэхийн тулд ингэж бид нар бүх гишүүдээр ингэж үг хэлүүлээ. Энэ бол бас маш чухал. Нийгмийн бодлогын байнгын хороо бол ард иргэдийн амьдралд тулгамдаж байгаа нийгмийн бүхий л өдөр тутмын асуудлуудыг хамардаг учраас үнэхээр энэ Сарангэрэл гишүүний хэлж байгаагаар зүгээр 1 цаглавар батлах төдийд хуулийн түвшинд бас ингээд аваад үзэж ингээд ярилцаж болохгүй сэдэв гэдгийг бид нар харгалзаж үзлээ.

Ингээд бүх гишүүдийнхээ саналыг бид нар сонслоо. Маш үнэ цэнтэй саналуудыг хэллээ. Эдгээр бүх асуудлуудыг бид нар Нийгмийн бодлогын

байнгын хорооныхоо түвшинд ярилцах, хэлэлцэх асуудлын дараалалд оруулж, та бүхнийхээ бас манлайллыг хангаж ингэж ажиллах бүрэн бололцоог бас Нийгмийн бодлогын байнгын хорооны зүгээс хангаж ажиллана гэдгээ та бүхэндээ хэлье.

Нийгмийн бодлогын байнгын хороогоор 3 дугаар сард хэлэлцэх цаглаврыг батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя гишүүд ээ.

61.5 хувиар тогтоол батлагдлаа.

Сая бас асуусан, яригдсан асуудлууд дунд энэ Эмийн түр хороо Түр хороо чигээрээ цаашаа үргэлжлэх үү, ажлын хэсэг байгуулагдах уу гэдэг тал дээр бүгдээрээ энэ Байнгын хороон дээрээ нээлттэй ярилцъя. Юутай чиг бас энэ Эмийн түр хороонд байгаа гишүүд нь өөрсдөө шахаж энэ тайланг бас яаралтай тавиулах тал дээр Түр хорооны гишүүд бас идэвхтэй ажиллаарай гэдгийг бас та бүхэндээ хэлье.

Ингээд Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөлөө.

Хуралдаа идэвхтэй оролцсон эрхэм гишүүд та бүхэндээ баярлалаа.

16.06 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

